



## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр

Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх *дунд хугацааны хөтөлбөр*”-ийг 2016 оноос хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн *Залуу үед санхүүгийн боловсрол олгох* тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийт их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт мэргэжил харгалзахгүйгээр *Хувь хүний болон өрхийн санхүү сэдэвт* хичээлийг оруулахаар төлөвлөөд байгаатай холбогдуулан сурах бичиг, дасгал ажлын номыг боловсруулах багийг сонгон шалгаруулах гэж байна. Иймд санхүүгийн удирдлагаар мэргэшсэн баг бүрэлдэхүүнтэй их, дээд сургуулиудыг уг ажлыг хийж гүйцэтгэх үнийн санал ирүүлэхийг урьж байна. Багийн гишүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

1. Багшлах эрхийн үнэмлэхтэй;
2. Их, дээд сургуульд санхүүгийн удирдлагын чиглэлээр 5-аас дээш жил багшилсан байх (нотлох баримтыг хавсаргасан байх);
3. Их, дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт нийцсэн ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлсэн туршлагатай байх.

Сонирхсон баг, хуулийн этгээд нь дараах материалыг бүрдүүлэн 2016 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 16 цаг 00 минутаас өмнө Монголбанкны Төв байрны бичиг хэрэгт ирүүлнэ үү.

Үүнд:

1. Ажил гүйцэтгэх санал;
2. Ажил гүйцэтгэх үнийн санал.

Ажлын даалгавар болон холбогдох бусад материалыг сонирхсон этгээдэд хүсэлтийн дагуу гаргаж өгнө.

Дээрх ажлуудтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг 312939 утсаар лавлана уу.

**МОНГОЛБАНК**  
**Бага тойруу-3, 15160**  
**Улаанбаатар-46, Монголбанкны**  
**“А” /төв/ байрны 1-2 тоот өрөө**  
**Утас: +11- 310392, Факс: +976-11-311471**